



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих хууль, журмын хэрэгжилт



**СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ ХУДАЛДАХ,
ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ОЛГОХДОО
ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААГ БАРИМТЛААГҮЙ БАЙНА.**

2018 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгийн тайлбар3
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5
Дарга, Тэргүүлэх аудитор	БҮЛЭГ 1. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагаанд холбогдох хууль журмыг баримталж ажиллаагүй байна.
Б.Сарантуяа	1.1 Тусгай зөвшөөрлийн 39.7% нь хуулийн хүрээнд олгогдоогүй байна.
Аудитын менежер	1.2 2016-2017 онд нийт 9 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгах үйл явц хуулийн хугацаанд хийгдээгүй, тэмдэгтийн хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй иргэн, ААНБ-д тусгай зөвшөөрөл олгосон байна.
Г.Наранбаяр	
Аудитор	БҮЛЭГ 2. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт хууль журмын дагуу хийгдэж байгаа хэдий ч үр дүнгүй байна.
Б.Дарханбат	2.1 Хяналт шалгалт хангалтгүйгээс үйл ажиллагаа явуулаагүй болон зөрчил гаргасан зарим иргэн, ААНБ-ын тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байна.
Аудитор	2.2 Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажилласан боловч үр дүн хангалтгүй байна.
Б.Анхтуяа	2.3 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны талаар ил тод мэдээлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.
2018 оны 06 дугаар сар	Дүгнэлт
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3156, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу.	Зөвлөмж
ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 208 тоот	

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ААНБ	Аж, ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОБГ	Онцгой байдлын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ХЗХ	Хууль зүйн хэлтэс
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторт Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилго, зорилт

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих хууль, журмын хэрэгжилтэд Нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ. Үүнд:

1. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагаа хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх
2. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт хууль журмын дагуу үр дүнтэй хийгдсэн эсэх

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, сумдын Засаг дарга, холбогдох ажилтнуудын баримт материал, мэдээ тайлан, судалгаанд тулгуурлан 2016-2017 оны үйл ажиллагааг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын журам, АДБОУС 100, 400, 4100 стандартууд, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Б.Дарханбат, аудитор Б.Анхтуяа нар гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

Аудитын явцад аймгийн Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ш.Ариунсан нь хугацаатай албан бичгийг 10 хоногоор хоцроосон, шаардлагатай мэдээ, тайланг тогтоосон хугацаанд ирүүлээгүй зэрэг нь аудитын явцад хүндрэл учрууллаа.

8. Үндсэн мэдээлэл

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 04 дүгээр тогтоолоор “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг баталж, уг журмын дагуу аймгийн Засаг дарга, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн дагуу сумдын засаг дарга нар Тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож байна.

Аймаг, сумдын засаг дарга нь “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарь”, “Архи, тамхигүй нэг өдөр”-ийг захирамжаар баталж, орон нутагтаа мөрдүүлэн ажиллаж байна. Мөн согтууруулах ундаа, тамхи худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олголт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих комиссыг томилон хяналтын үүргээ хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны эцсийн байдлаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 44, тамхины худалдаа, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 24 иргэн, аж ахуйн нэгж байгууллага байгаагаас 64 иргэн, ААНБ үйл ажиллагаагаа явуулж байна.

Бүлэг 1

Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагаанд холбогдох хууль журмыг баримталж ажиллаагүй байна.

1.1. Тусгай зөвшөөрлийн 39.7% нь хуулийн хүрээнд олгогдоогүй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн байдлаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 44, тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 24 иргэн, аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй хуулийн этгээдийн үйл ажиллагааны төрлийг авч үзвэл хүнсний дэлгүүр 54, зоогийн газар 9, ресторан 1, баар 2, кафе 2 байна.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг аймаг, сумдаар нь харуулбал:

№	Аймаг, сумын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл		
		Согтууруулах ундаа худалдах	Согтууруулах ундаагаар үйлчлэх	Тамхи худалдах
1	Сүмбэр сум	22	10	15
2	Шивээговь сум	5	3	5
3	Баянтал сум	3	1	4
	Нийт дүн	30	14	24

Хүснэгтээс харахад: Тусгай зөвшөөрлийн 69.1 хувийг Сүмбэр сум, 19.1 хувийг Шивээговь сум, 11.8 хувийг Баянтал сум тус тус эзэлж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт зааснаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг дарга, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт зааснаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийг сумдын Засаг дарга олгож байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/18 дугаартай захирамжаар согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цагийн хуваарь, Сүмбэр сумын Засаг даргын 2017 оны А/14 дугаартай захирамж, Шивээговь сумын Засаг даргын 2016 оны А/88 дугаартай захирамжаар согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цагийн хуваарийг баталсан байна. Баянтал сумын Засаг дарга нь захирамж гаргаагүй ба аймгийн Засаг даргын захирамжийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт зааснаар аймгийн ИТХ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолоор “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг баталсан боловч уг журмыг Хууль зүйн яамны “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлээгүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйлчилгээний төрлийг 2016, 2017 оноор диаграммаар нэгтгэн харуулбал:



Диаграмаас харахад: Тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагуудын 44% нь согтууруулах ундаа худалдах, 35% нь тамхи худалдах, 21% нь согтууруулах ундаагаар үйлчлэх зөвшөөрөлтэй байна. Үүнээс давхар буюу 2-3 тусгай зөвшөөрөлтэй ААНБ 14 буюу 20.5%-ийг эзэлж байна. Тухайлбал: согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 2, согтууруулах ундаа худалдах, тамхи худалдах 10, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 2 байгууллага байна. /Дэлгэрэнгүй судалгааг Хавсралт №1-ээс үзнэ үү/

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын тоо 2017 онд өмнөх оноос 6 буюу 8.8%-иар өссөн байна.

Өмнөх онуудад согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо комисс томилолгүйгээр сумдын Засаг даргаар дамжуулан дэмжих эсэх талаарх албан бичгийн хамт аймгийн Засаг даргад хүсэлтийг хүргүүлж, тусгай зөвшөөрлийг олгож, сунгалтыг хийж ирсэн байна.

2017 оноос согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн олголт, сунгалтыг эмх замбараатай, хүнд суртал, чирэгдэлгүй олгох зорилгоор аймгийн Засаг даргын 2017 оны А/340 дугаартай захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй комиссыг томилж, “Архи, согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгох, хяналт тавих комиссын ажиллах журам”-ыг баталсан байна.

Гэвч 2017 онд томилогдсон комисс ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, тусгай зөвшөөрлийг иргэн, ААНБ-д шинээр олгосон болон сунгалт хийгдсэн талаарх ажлын тайлан байхгүй, журмын дагуу комиссын хурал хийж хэлэлцсэн гэх боловч хурлын тэмдэглэлийг бүрэн хөтлөөгүй, холбогдох баримт материалыг бүрдүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр хувийн хэрэг нээж ажиллаагүй байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, АИТХ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-д зааснаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо иргэн, ААНБ-уудаас 8 төрлийн баримт материалыг хүлээн авч бүрдүүлэхээр журамлагдсан байна.

Тусгай зөвшөөрлийг олгохдоо дутуу бүрдүүлсэн баримтын судалгааг он тус бүрээр графикаар харуулбал:

Баримтын бүрдэл дутуу байгууллагуудын тоо



Графикаас харахад тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авахдаа 2016 онд 21, 2017 онд 32 байгууллагаас давхардсан тоогоор нийт 92 баримт бичгийг бүрдүүлээгүй байна. Тухайлбал: тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан өргөдөл 2016, 2017 онд тус тус 3, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг 2016 онд 1, 2017 онд 4, татвар төлөгчөөр бүртгүүлсэн хуудсыг 2016 онд 1, 2017 онд 8, гадна талбайн тохижилтын зургийг 2016 онд 18, 2017 онд 7, тохирлын гэрчилгээний хуулбарыг 2016 онд 7, 2017 онд 6, галын аюулгүй байдлын дүгнэлтийн хуулбарыг 2016 онд 12, 2017 онд 6, сумын засаг даргын албан тоотыг 2016 онд 1, 2017 онд 15 байгууллага дутуу бүрдүүлсэн байна. /Хавсралт № 2, 3/

АИТХ-ын 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Архи, согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгох, хяналт тавих комиссын ажиллах журам”-уудын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. 2017 оны 10 дугаар сараас тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгалт хийлгэх хүсэлт гаргасан иргэн, ААНБ-аас шаардлагатай баримт материалыг бүрэн бүрдүүлж аваагүй байна. Тухайлбал: согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх 17 ААНБ-ын тусгай зөвшөөрөлд сунгалт хийгдсэн ба “Хөвхөрийн арал” ХХК, “ДСБНТ” ХХК, “Бидний хад” ХХК, УБТЗ-ын “Ган зам” дэлгүүр, “Шинэ гранд” ХХК, “Уул баян сүмбэр” ХХК, “ОЖС” ХХК, “Дэлгэрэхбилэг” ХХК, “Андууд” 1, 2, “Хүрээ инвест” ХХК, “Залаагийн одь” ХХК, “Дорнын оточ” ХХК, “Тэргүүн сүмбэр” ХХК, “Мэргэн дунгаа” ХХК, “Жеззабел” ХХК, “Шинэ боржигон” ХХК, “ББОГ” ХХК, “Мөнххүлэг хурд” ХХК-ийн тусгай зөвшөөрөл олгох, сунгахтай холбоотой комиссын хурлын тэмдэглэлийг иж бүрэн хөтлөөгүй, хурлын тэмдэглэлээр ямар шийдвэр гарсан нь тодорхойгүй,

тэмдэглэлд комиссын гишүүдээр гарын үсэг зуруулж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, АИТХ-ын 2016 оны 4 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 3.1, аймгийн Засаг даргын баталсан “Архи, согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгох, хяналт тавих комиссын ажиллах журам”-ыг тус тус зөрчсөн байна.

2. Сумдууд тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоходоо иргэд, ААНБ-аас харилцан адилгүй баримт бичгийг хүлээн авч, холбогдох хуулийг зөрчсөн байна. Тухайлбал: Баянтал, Шивээговь сумдад зөвхөн тусгай зөвшөөрөл хүссэн гар өргөдөл авч байгаа бол, Сүмбэр суманд тусгай зөвшөөрөл хүссэн гар өргөдөл, багийн засаг даргын тодорхойлолт, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон иргэний үнэмлэхний хуулбарыг бүрдүүлсэн байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 хэсгийг зөрчсөн байна.

3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2016 онд 7, 2017 онд 32 байгууллагад тус тус 1 жилийн хугацаатай олгосон байна.

Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 хэсэг, “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

4. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн хугацааг сумдад харилцан адилгүй буюу нийт 14 хуулийн этгээдэд зөрүүтэй олгосон байна. Тухайлбал: Сүмбэр сум 2015 онд хугацаа заагаагүй 7, 2016 онд 2 жилийн хугацаатай 1, хугацаа заагаагүй 3, 2017 онд 1 жилийн хугацаатай 1, Баянтал сум 2015 онд хугацаа заагаагүй 2 иргэн, ААНБ-д тус тус олгосон байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Тамхины тусгай зөвшөөрөл олгох хяналт тавих журам”-ын 2.1 дахь хэсгийг зөрчсөн байна.

Аудитын явцад илэрсэн дээрх зөрчил дутагдлаас харахад “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулаагүйгээс журмын зарим заалт, хуулийн заалттайгаа зөрчилдсэн, иргэдийн саналыг аваагүй, Хууль зүйн ямаар баталгаажуулаагүй, аймгийн Хуульзүйн хэлтсээс сумдаас гаргасан тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгох журам хуулийн хүрээнд боловсруулагдсан эсэхэд хяналт тавиагүй байна.

Иймд холбогдох журмуудыг шинэчлэн батлуулах, тусгай зөвшөөрөл олгоход шаардлагатай баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хуульд заасан хугацааг баримтлах, согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгох, хяналт тавих комисс нь аймгийн ИТХ-ын баталсан журмыг баримтлан ажиллах, жил бүр ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайлан болон холбогдох хурлын тэмдэглэл, бүрдүүлсэн баримт материалыг архивлах, тусгай зөвшөөрөл

эзэмшигчид хувийн хэрэг нээх, хийсэн ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар жилд нэг удаа хэлэлцүүлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.


Говьсүмбэр аймагт Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлүүдийг олгоход мөрдөх чиглэл, норматив, байршлыг Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалыг баримтлан ажиллаж байгаа боловч согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог нормативтай харьцуулахад нийт 77.3 хувиар хэтрүүлэн олгосон байна. Тухайлбал: Тусгай зөвшөөрлийн цэгийн тоог Сүмбэр суманд 81.3%, Шивээговь суманд 75.0%, Баянтал суманд 50.0%-иар тус тус хэтрүүлэн олгожээ.

Энэ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар баримталж байгаа нормативыг тус тус зөрчсөн байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар нийслэл, аймгийн төвд 2000 хүн ам тутамд 1-ээс хэтрэхгүй, сумын төвд согтууруулах ундаа худалдах цэг 1, согтууруулах ундаагаар үйлчлэх цэг 1 байхаар тогтоосон боловч энэ нь тус аймагт хэрэгжээгүй байна.

Аймгийн хэмжээнд Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоог, нормативтай харьцуулсныг графикаар харуулбал:

Харьцуулалт



Графикаас харахад: Одоо мөрдөгдөж байгаа Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 5 дугаар тушаалын дагуу Сүмбэр суманд 6 байхаас 32 буюу 81.3%, Шивээговь суманд 2 байхаас 8 буюу 75.0%, Баянтал суманд 2 байхаас 4 буюу 50.0%-иар нормативаас хэтэрсэн байна. Нормативыг мөрдөж ажиллаагүй шалтгааныг тодруулахад орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, цэгийн тоог бууруулах тусам архидан согтуурах байдал ихсэх, хууль бусаар согтууруулах ундаа худалдах зэрэг сөрөг хандлагатай гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Сумдын Засаг даргын нарын эрхийн хүрээнд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгож байгаа бөгөөд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дахь заалтын хэрэгжилтийг хянах зорилгоор аймгийн ГХБХБГ-аас 1, 2, 3, 4, 5 дугаар сургуулиудын хичээлийн болон дотуур байрнаас /тухайн объектын төв цэгээс/ 500 метр зайг тодорхойлсон зураглалыг гаргуулан авч үзэхэд Шивээговь, Баянтал суманд сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метр зай дотор багтсан тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй цэг байхгүй байна.

Аудитын явцад тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. ГХБХБГ-аас ирүүлсэн 500 метрийн зураглалыг үндэслэн тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон цэгийн тоог хянаж үзвэл Сүмбэр суманд Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дахь заалтыг зөрчиж 500 метрийн дотор “Залаагийн одь” ХХК, “Залаат дэлгүүр”, “41” хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгосон байна.
2. Сүмбэр суманд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгохдоо иргэн, ААНБ-уудад ялгавартай хандсан байна. Тухайлбал: “Дорнын оточ” ХХК-ийн “Мөнхөт” дэлгүүр нь тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2015 онд авсан бөгөөд 2 жилийн хугацаа дуусч, тусгай зөвшөөрлийг сунгуулах хүсэлтээ 2017 оны 4 дүгээр сард Сүмбэр сумын Засаг даргад албан ёсоор өгсөн боловч сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метр дотор зайд багтсан тул олгох боломжгүй гэсэн хариуг 2017.10.09-нд албан бичгээр хүргүүлсэн нь иргэдээс ирсэн хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлээгүй, хүнд суртал, чирэгдэл учруулсан, гэтэл 500 метр дотор зайд багтсан “Залаагийн одь” ХХК, “Залаат” дэлгүүр, “41” хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгосон нь төрийн байгууллага иргэдэд хууль дээдлэх, тэгш, хүртээмжтэй, шударга, ёс зүйтэй байх, өрсөлдөх байдлыг хангахуйц байхаар үйлчилгээ үзүүлээгүйг харуулж байна.
3. Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх заалт нь 500 метрийн зайг тухайн объектын яг аль цэгээс авч хэмжээг тооцох нь тодорхойгүйгээс сумдад газрын зураглалыг харилцан адилгүй хэмжиж байна. Сумдын хэмжээнд 500 метрийн зураглалыг гаргах талаар нэгдсэн бодлого, чиглэл баримталж ажиллаагүй, хуулийн цоорхойг ашиглаж иргэн, ААНБ-уудад ялгавартай хандаж байгаад цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дээрх зөрчлүүд нь Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.7.14, 2013 оны 191 дүгээр Засгийн газрын тогтоолоор “Тамхины үйлдэрлэл, импорт, худалдаа үйлчилгээнд хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог норматив, хүн амын тоо мэдээг үндэслэн бууруулах, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгохдоо хууль, журамд нийцүүлэн орон нутгийн эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэгчдийг дэмжих, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан бизнес эрхлэгчдэд эрх тэгш хандах, тамхи худалдах цэгийг тодорхойлсон зураглалыг гаргахдаа сумдын хэмжээнд нэгдсэн бодлого, чиглэл баримталж ажиллах, зураглалыг баталгаажуулж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын 2011 оны 05 дугаар тогтоолоор баталсан үнэлгээг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг тус тус ногдуулж байна.

Иргэн, ААНБ-д ногдуулсан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжид 2016 онд 9,290.0 мянга, 2017 онд 12,360.0 мянган төгрөгийг аймгийн тэмдэгтийн хураамжийн дансанд

төвлөрүүлэхээр, 2015-2017 онд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжинд 6,750.0 мянган төгрөгийг сумдын орон нутгийн дансанд төвлөрүүлэхээр тус тус ногдуулсан байна.

Аудитаар тэмдэгтийн хураамжийн ногдуулалт, төвлөрүүлэлтийг шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. 2016 онд 1 ААНБ-д согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг 400.0 мянган төгрөгөөр дутуу ногдуулж, тэмдэгтийн хураамжийг нөхөн төлүүлээгүй байна. Тухайлбал: “Боржигон Сондор” ХХК-д сул болон өндөр агууламжтай үйлчлэх тусгай зөвшөөрлийг анх олгохдоо тэмдэгтийн хураамжийг 400.0 мянган төгрөгөөр дутуу ногдуулснаас 400.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг бүрэн төлөөгүй байхад согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.
2. Сүмбэр сум 2015-2016 онд тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн нийт 1,250.0 мянган төгрөгийн бүрэн төлөөгүй 5 иргэн, ААНБ-д тусгай зөвшөөрөл олгосон байна. Тухайлбал: “Сансар Хайрхан” ХХК-250.0 мянга, “Дэвжих” дэлгүүр-250.0 мянга, Ц.Батжаргал “Жанжин” дэлгүүр-250.0 мянга, Дэлгэрэхбилэг” ХХК-ийн “Андууд” мини маркет-250.0 мянга, “Тэргүүн Сүмбэр” ХХК-250.0 мянган төгрөг тус тус дутуу төвлөрүүлсэн байна.

Эдгээр нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Иймд дутуу төвлөрүүлсэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн 400.0 мянга, тамхи худалдах тусгай зөвшөөрлийн 1,250.0 мянга, нийт 1,650.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

1.2 2016-2017 онд нийт 9 байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл явц хуулийн хугацаанд хийгдээгүй, тэмдэгтийн хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй иргэн ААНБ-д тусгай зөвшөөрөл олгосон байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар 2016-2017 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 10 иргэн, ААНБ-д, Сумын засаг даргын захирамжаар тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2015-2016 онд 21 байгууллагад тус тус шинээр олгосон байна. Шивээговь, Баянтал суманд тусгай зөвшөөрөл олгох талаар иргэн, ААНБ-аас хүсэлт ирээгүй байна.

Тусгай зөвшөөрөл шинээр олгосон байгууллагын тоог сумдаар нь ангилан хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэрс	2016	2017
		Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх	
1	Сүмбэр	4	3
2	Шивээговь	1	-
3	Баянтал	1	1
	Нийт	6	4

№	Сумдын нэрс	Тамхи худалдах	
		2015	2016
1	Сүмбэр	6	4
2	Шивээговь	3	2
3	Баянтал	3	3
Нийт		12	9

Хүснэгтээс харахад: согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2016 онд шинээр 6, 2017 онд 4, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг 2015 онд 12, 2016 онд 9 иргэн, ААНБ-д олгожээ. Өмнөх онтой харьцуулахад шинээр олгосон тусгай зөвшөөрлийн тоо буурсан байна.

2016-2017 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 6, тамхи худалдах зөвшөөрлийг 3 иргэн, ААНБ-д тус тус хуульд заасан хугацааг баримтлаагүй, шийдвэрлэвэл зохих хугацааг хэтрүүлж олгосон байна.

Хугацаа хэтрүүлсэн хоногийн тоог байгууллагаар нь харуулбал:

№	Байгууллагын нэр	Хуульд заасан хугацааг хэтрүүлж олгосон хоногийн тоо		Сумын нэр
		2016	2017	
Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх				
1	“Боржигон Сондор” ХХК	11		Сүмбэр
2	“Сүмбэр Алт” ХХК	28		Сүмбэр
3	“Гэээгт” ЗБН		59	Сүмбэр
4	“Оюут Боржигон” ХХК		2	Баянтал
5	“ДХББ” ХХК		20	Сүмбэр
6	“Мишээгч Очир” ХХК		16	Сүмбэр
Тамхи худалдах				
1	Э.Сүхбаатар “Ханхөхий” дэлгүүр	7		Сүмбэр
2	О.Дэлгэрбаяр “Мандахнаран” дэлгүүр	29		Баянтал
3	Ё.Нансалмаа “Арвижих” дэлгүүр	3		Баянтал

Хүснэгтээс харахад: 2016-2017 онд нийт 9 иргэн, ААНБ-ын тусгай зөвшөөрөл олгохдоо хуульд заасан хугацааг баримтлаагүй бөгөөд 2016 онд 5 иргэн, ААНБ-д 3-29 хоног, 2017 онд 4 ААНБ-д 2-59 хоног хэтрүүлж шийдвэрлэсэн байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг зөрчсөн байна.

2016-2017 онд аймгийн Засаг даргын захирамжаар 40 байгууллагын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 1 байгууллагад түр зөвшөөрөл олгосон байна. 2015-2017 онд Сумын засаг даргын захирамжаар 8 байгууллагын тамхи худалдах тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

Тусгай зөвшөөрөлд сунгалт хийсэн байгууллагын тоог хүснэгтээр харуулбал:

№	Сумдын нэрс	2016	2017
		Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх	
1	Сүмбэр	7	22
2	Шивээговь	4	5
3	Баянтал	1	1
Нийт		12	28

Тамхи худалдах			
№	Сумдын нэрс	2015	2016
1	Сүмбэр	3	3
2	Шивээговь	-	2
3	Баянтал	-	-
Нийт		3	5

Хүснэгтээс харахад: Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн сунгалтыг 2016 онд 12, 2017 онд 28, тамхи худалдах тусгай зөвшөөрлийн сунгалтыг 2015 онд 3, 2016 онд 5 иргэн, ААНБ-д олгосон байна. Өмнөх онтой харьцуулахад сунгалт хийсэн тусгай зөвшөөрлийн тоо өссөн байна.

2016-2017 онд нийт 9 байгууллагын согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн сунгалтыг хийхдээ хуульд заасан хугацааг баримтлаагүй, шийдвэрлэвэл зохих хугацааг хэтрүүлж олгосон байна

Хугацаа хэтрүүлсэн хоногийн тоог хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	Сунгалт хийхэд хоног хэтрүүлж олгосон хоногийн тоо		Сумын нэр
		2016	2017	
Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх				
1	Бодь зам ХХК		21	Сүмбэр
2	Сансарт Хайрхан ХХК		22	Сүмбэр
3	Эн Ди Ти ХХК		49	Сүмбэр
4	Тэргүүн Сүмбэр ХХК		31	Сүмбэр
5	Цэдэн хан ХХК		42	Баянтал
6	Чойр Хайрхан Сүмбэр ХХК		15	Шивээговь
7	Хүрээ инвест ХХК		28	Сүмбэр
8	Сүмбэр Алт ХХК	28		Сүмбэр
9	Дэлгэрэх билэг ХХК	27		Сүмбэр

Хүснэгтээс харахад: 2016 онд 2 байгууллагад 27-28 хоног, 2017 онд 7 байгууллагад 15-49 хоногоор тус тус хуульд заасан хугацааг хэтрүүлж олгосон байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг зөрчсөн байна.

Тусгай зөвшөөрлийг сунгах үйл ажиллагааг хуулийн хүрээнд шийдвэрлээгүйгээс иргэд, ААНБ нь тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байхад үйл ажиллагаагаа явуулж зөрчилд орох эрсдэлтэй байна.

Иймд тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгахдаа хуульд заасан хугацааг баримтлан ажиллах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн хэмжээнд 2016-2017 онд 1,650.0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг бүрэн төлөөгүй 6 байгууллагад тусгай зөвшөөрлийг олгосон байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 заалт, 35 дугаар зүйлийн 35.2 хэсгийг зөрчсөн байна.

Бүлэг 2

Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтын үр дүн хангалтгүй байна.

2.1. Хяналт шалгалт хангалтгүйгээс үйл ажиллагаагаа явуулаагүй болон зөрчил гаргасан зарим иргэн, ААНБ-ын тусгай зөвшөөрлийг цуцлаагүй байна.

Аудитын явцад нийт 57 иргэн, ААНБ-ын үйл ажиллагаатай танилцсан ба 37 буюу 64.9% нь согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй, 20 буюу 35.1% нь тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй байлаа. Үүнээс согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх 2 буюу 3.5%, согтууруулах ундаа худалдах, тамхи худалдах 10 буюу 17.5%, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй 2 буюу 3.5% байгууллага байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагааг худалдаа, үйлчилгээ, худалдааны газар, түүний үйлчилгээ, Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлагын хүрээнд түүвэрлэн шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

1. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудаас 8.3% нь тохирлын гэрчилгээгүй, 5.5% нь галын аюулгүй байдлын дүгнэлт байхгүй, 35.7% нь хатуу хучилттай зам зогсоол байхгүй, 22.2% нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн самбаргүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх тохижилт хийгдээгүй байна. “Мишээгч Очир” ХХК-ийн Оргил Ундраа дэлгүүрээс бусад нь ипмортын архины гаалийн шинжилгээний бичиггүй байна.
2. Согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 4 ААНБ үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй байна. Тухайлбал: “ДХББ” ХХК, “Дорнын оточ” ХХК, “Бэлгэхэг хайрхан” ХХК, “Мишээгч Очир” ХХК-ын “Наран” кафе нь үйл ажиллагаагаа тогтмол явуулаагүй байна.
3. Говьсүмбэр аймагт тамхи худалдах тусгай зөвшөөрөлтэй иргэн, ААНБ-уудын зөвшөөрөлтэй цэгийг тодорхойлсон зураглалыг баталгаажуулаагүй, Сүмбэр суманд сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метр дотор зайд багтсан “Залаагийн одь” ХХК, Залаат дэлгүүр, “41” дэлгүүрүүдэд тусгай зөвшөөрөл олгосон байна.
4. 2015, 2016 онд нийт 14 байгууллагуудад тамхи худалдах тусгай зөвшөөрлийг Сүмбэр, Баянтал сумын Засаг даргын захирамжаар олгосон боловч захирамжид хуульд заасны дагуу 3 жилээр олгохоор байтал зөвшөөрлийн хугацааг тодорхой заалгүй хугацаагүйгээр олгосон байна.

Эдгээр нь Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 хэсэг, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 заалт “Худалдаа, үйлчилгээ, худалдааны байгууллагын ангилал, тодорхойлолт MNS 6506:2015”, “Худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS 4946:2005” стандартыг зөрчсөн байна.

Иймд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгосон захирамжийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааны төрлөөс хамаарч стандартын шаардлага хангасан байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгож байх, үйл ажиллагаа явуулахгүй байгаа байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хураах, хүчингүй болгох арга хэмжээ авах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэвлүүлэх болон бүртгэх, хяналт тавих талаар журамлаагүйгээс нэгдсэн журмаар дугаарлаж, бүртгэл хөтлөөгүй, А4 хэмжээтэй, өнгийн цаасанд хэвлэн гаргаж байна.

Сүмбэр сум тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгоход ногдуулсан тэмдэгтийн хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байхад 5 иргэн, ААНБ-д зөвшөөрөл олгожээ.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 заалтыг зөрчсөн байна.

Цаашид тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэвлүүлэх, бүртгэх, дугаарлах, түүнд хяналт тавих асуудлыг тодорхой болгон журамлах, тэмдэгтийн хураамжийг бүрэн төвлөрүүлээгүй иргэн, ААНБ-д тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй, сунгахгүй байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.2 Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтэд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажилласан боловч үр дүн хангалтгүй байна.

2016-2017 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудад аймгийн МХГ, ОБГ, Татварын хэлтэс, Цагдаагийн хэлтсээс нийтдээ 9 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна.

МХГ нь 2016 онд согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 36 ААНБ-д хяналт шалгалт хийсэн ба тус шалгалтаар нийт 126 зөрчил илрүүлж, зөрчлийн 27 буюу 21.0%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчил арилгах 49 заалт бүхий 13 албан шаардлагыг 13 байгууллагад хүргүүлсэн байна. Хяналт шалгалтын хэрэгжилт 78.0%-тай гарсан бөгөөд санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжээгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/137 дугаартай захирамжаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор аймгийн ЗДТГ, МХГ, Татварын хэлтэс, ОБГ зэрэг байгууллагуудын хамтарсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилсон байна.

Уг ажлын хэсэг нь согтууруулах ундаагаар үйлчилдэг 12, худалдаа үйлчилгээний 27 ААНБ-д хяналт шалгалт хийсэн байна. Хяналт шалгалтаар нийт 194 зөрчил илрүүлж, зөрчлийн 24 буюу 12.0%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчил арилгах 123 заалт бүхий 31 албан шаардлагыг 31 ААНБ-д хүргүүлсэн байна.

Хамтарсан багийн хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- 4 аж ахуй нэгжийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй / “Мэргэн дунгаа” ХХК, “Сүмбэр Алт” ХХК, “Бодь зам” ХХК, “Шинэ Гранд” ХХК /
- 2 аж ахуй нэгж ажиллагсдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулаагүй / “Цэдэн хан” ХХК, “Шинэ Гранд” ХХК /
- 2 аж ахуй нэгж тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан байхад согтууруулах ундаа худалдан борлуулж байсан / “Хүрээ инвест” ХХК-14 хоног, “Цэдэн хан” ХХК-2 сар / “Чойр Хайрхан Сүмбэр” ХХК нь зөвхөн өндөр агууламжтай тусгай зөвшөөрөлтэй байхад сул агууламжтай согтууруулах ундаа худалдсан
- “Хүрээ инвест” ХХК нь тусгай зөвшөөрөлгүй согтууруулах ундаа худалдаалж байсныг тогтоож 87 ширхэг архи хураан авсан,
- “Бидний Хад” ХХК, “Гэээгт ЗБН” ХХК, “Сүмбэр Алт” ХХК нь ажиллах цагийн хуваарь хэтрүүлсэн
- “Мэргэн дунгаа” ХХК нь насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдан борлуулсан
- 5 байгууллага кассын машин ажиллуулаагүй, татвараа хугацаанд нь төлөөгүй
- “Хүрээс Инвест” ХХК нь орон нутагт татвар төлөгчөөр бүртгүүлээгүй
- 1 иргэн тусгай зөвшөөрөлгүй тамхи болон гар дээрээс хууль бусаар согтууруулах ундаа худалдан борлуулсан байна.

Шалгалтын дүнд үндэслэн аймгийн Таварын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, МХГ-аас цаашид авах арга хэмжээний саналыг аймаг, сумдын ЗДТГ болон ААНБ-уудад хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүйгээс зөвлөмжийн хэрэгжилтийг тооцоогүй байна. Тухайлбал:

- Орон нутагт Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 05 дугаар тушаалаар батлагдсан нормативыг аймаг болон сумдад баримтлах
- Хүнсний чиглэлээр 2-3 жил тогтвортой үйл ажиллагаа явуулж, дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлж хэвшсэн, стандартын шаардлага хангасан барилга, байгууламжтай газруудад тусгай зөвшөөрлийг олгох
- Аймаг, сумдын ЗДТГ-аас тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудад тавих дотоод хяналтыг сайжруулах
- Тусгай зөвшөөрөлтэй газруудад тавигдах шаардлагыг бүрэн хангахгүй, удаа дараа буюу ноцтой зөрчсөн байгууллагуудын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, дахин сунгахгүй байх
- “Хүрээс Инвест” ХХК нь орон нутагт татвар төлөгчөөр бүртгүүлээгүй тул тусгай зөвшөөрлийг цуцлуулах

Аймгийн Цагдаагийн хэлтсээс хийгдсэн хяналт шалгалтаар 63 зөрчлийг илрүүлж, 2016 онд 3,019.0 мянга, 2017 онд 950.0 мянга, нийт 3,969.0 мянган төгрөгийн шийтгэл ногдуулж ажилласан байна. Үүнээс: согтууруулах ундаа худалдах цагийн хуваарь хэтрүүлсэн ААНБ-д 1,499.0 мянга, зөвшөөрөлгүй тамхи худалдсан 12 дэлгүүрт 2,470.0 мянган төгрөгийн торгуулийг тус тус ногдуулсан байна.

ОБГ-ын хяналт шалгалтаар нийт 79 зөрчил илрүүлснээс 24 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 55 зөрчлийг арилгуулах талаар сануулах арга хэмжээ авч нийт 58 иргэнд яриа таниулга хийсэн байна. /Хавсралт №03 /

Цагдаагийн хэлтэс нь 2016 оны 10 сард МХГ-тай хамтран согтууруулах ундаагаар худалдаа үйлчилгээ эрхлэгч ААНБ-уудад хяналт шалгалт хийсэн ба шалгалтанд нийт 39 ААНБ хамрагдсан байна. Шалгалтаар нийт 126 зөрчил илрүүлж, зөрчлийн 27 буюу 21%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчил арилгах 49 заалт бүхий 13 албан шаардлагыг 13 газарт хүргүүлсэн байна.

2017 оны 11 дүгээр сард “Амар тайван сүмбэр” аяны хүрээнд согтууруулах ундаа худалддаг, үйлчилдэг 39 ААНБ-уудын цагийн хуваарь, хуулиудын хэрэгжилтийг хангуулж ажиллажээ.

Цагдаагийн хэлтэс нь 2017 онд Тамхины хяналтын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулсан Баянтал сумын иргэн Ё.Нансалмаа, Сайжрах, Болор хүнсний дэлгүүрээс 272 хайрцаг тамхи хураан авсан байна.

Сүмбэр сум нь 2016 онд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 25 ААНБ-уудад 1 удаагийн хяналт шалгалт, Шивээговь сум нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтээр 2017 онд 2 удаагийн хяналт шалгалтыг явуулсан байна.

Баянтал суманд хяналт шалгалтын ажил огт хийгдээгүй байна.

Хяналт шалгалтын тайлангаас харахад тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудад холбогдох чиглэлийн дагуу хяналт шалгалт тогтмол хийгдсэн боловч зөрчил дутагдлууд удаа дараа, давтан гарсаар байхад хяналт шалгалтын үр дүнгээр тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, зохион байгуулсан ажил байхгүй байна.

Аймаг, сумдын ЗДТГ нь Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.3, Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, зөрчлийг удаа дараа гаргасан ААНБ-ын тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Иймд Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Тамхины хяналтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасны дагуу холбогдох байгууллагуудад согтууруулах ундаа худалдах, хэрэглэх, түүгээр үйлчлэх талаар тогтоосон журмын биелэлт, тамхины хяналтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

2.3 Тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны талаар ил тод мэдээлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг бүрэн бүртгээгүй, хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.

Аймгийн ЗДТГ нь цахим хуудсанд тусгай зөвшөөрөл гэсэн цэс үүсгэн 2016, 2017 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг 2 удаа, 2017 оны хагас жилийн байдлаар тэмдэгтийн хураамжийн тайланг оруулсан байна.

Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын талаар мэдээллийг оруулаагүй байна.

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэд, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг бүрэн бүртгээгүй, хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.

Тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахаар иргэд, ААНБ-уудаас 80 өргөдөл өгснөөс 2016 онд 7, 2017 онд 11 иргэн, ААНБ-ын өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус зөрчсөн байна.

Мөн “Сүмбэр Сити” ХХК, иргэн Д.Мягмарбаатараас тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл өгсөн ба өргөдлийн хариуг олгох боломжгүй гэж амаар өгсөн гэх боловч татгалзсан үндэслэлийг албан бичгээр гаргаж хүргүүлээгүй байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг зөрчсөн байна.

Цаашид аймаг, сумдын ЗДТГ нь тусгай зөвшөөрөлтэй холбоотой иргэдийн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн ЗДТГ нь аймгийн цахим хуудсанд тусгай зөвшөөрөл гэсэн цэс үүсгэн 2016, 2017 онд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгаа, бүртгэлийг 2 удаа, 2017 оны хагас жилийн байдлаар тэмдэгтийн хураамжийн тайланг оруулсан байна. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой ажлын тайлан, мэдээ судалгаа гаргаагүй байна.

Аймаг, сумдын цахим хуудсанд оруулсан мэдээллүүдийг харуулбал:

№	Аймаг, сумын нэр	Цахим хаяг	Тусдаа цэстэй эсэх	Оруулсан мэдээллүүд
1	Аймгийн ЗДТГ	www.govisumber.gov.mn	Тийм	2016 онд 2 удаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн судалгаа, 2017 онд 2 удаа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн судалгаа, 2017 оны хагас жилийн байдлаар тэмдэгтийн хураамжийн тайлан
2	Сүмбэр	www.sumber.gs.gov.mn	Тийм	Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх жагсаалт
3	Шивээговь	www.shiveegovi.gs.gov.mn	Үгүй	Мэдээлэл байхгүй
4	Баянтал	www.bayantal.gs.gov.mn	Үгүй	Мэдээлэл байхгүй

Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын талаарх мэдээлэл, ажлын тайлан, судалгаа гаргаагүй, ил тодоор мэдээлээгүй байна.

Энэ нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан тусгай зөвшөөрөл олгохдоо ил тод байх зарчмыг баримтална гэснийг зөрчсөн байна.

Цаашид аймаг, сумдын ЗДТГ нь цахим хуудсанд “тусгай зөвшөөрөл” гэсэн бие даасан цэстэй болох, тусгай зөвшөөрөлтэй холбоотой хийгдсэн ажлын тайлан, мэдээ, судалгааг ил тодоор мэдээлж байх талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аймгийн Цагдаагийн хэлтсээс архи, тамхины хууль болон хор уршгийг таниулах талаар 2016-2017 онд дараах сургалт сурталчилгаа, ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2016 онд Политехник коллежийн 200 оюутнуудад Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар 2 удаагийн сургалт

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажлаа аймаг орон нутгийн телевизээр 20 минутын зайтай урсдаг зар хэлбэрээр сурталчилсан.
- 2017 онд “Амар тайван Сүмбэр” аяны хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулиудаар зөвлөгөө, сэрэмжлүүлэг эхийг бэлтгэсэн
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэвжээ” тэмцээн
- Гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа 21 иргэдэд “Архинд донтох өвчин, Архины нийгэм сэтгэл зүйн хор уршиг, Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл сэтгэл хөдлөл сэдэв”-т сургалт
- Ерөнхий боловсролын 1, 2, 5 сургууль, Политехник коллежийн нийт 770 оюутан сурагчдад Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хуулиудаар сургалт
- Шинэ жил нэгдсэн арга хэмжээний хүрээнд архи, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг 32 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уулзалт зөвлөгөөн

АЗДТГ-аас нь архи, тамхины хуулийн талаар болон хор уршгийг таниулах талаар 2016-2017 онд дараах сургалт сурталчилгаа, ажлуудыг зохион байгуулсан байна. Үүнд:

- 2016 оны 06 сард Хүний эрхийн үндэсний комисс, Цагдаагийн хэлтэстэй хамтран “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай” хуулиар 58 ажилтан, албан хаагчдад сургалт
- 2017 оны 11 сард согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 25 ААНБ-ын ажилтан, албан хаагчдад “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам” сэдэвт сургалт

Сүмбэр суманд 2017 оны 05 сард “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн нээлттэй өдөрлөгийг МХГ, ЭМГ-тай хамтран зохион байгуулсан арга хэмжээнд тамхины тусгай зөвшөөрөл эзэмшигч 13 иргэн, ААНБ хамрагдсан. Уг өдөрлөгөөр сурагчдын дунд “АХА” тэмцээн, гар зургийн уралдаан, гарын авлага зөвлөмж тараах зэрэг арга хэмжээнд зохион байгуулагдсан байна.

Шивээговь, Баянтал суманд архи, тамхины хуулийн талаар болон хор уршгийг таниулах сургалт, сурталчилгааны ажил огт хийгдээгүй байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Тамхины хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан архи, тамхины хуулийг сурталчлах, хор хөнөөлийн талаар сургалт, сурталчилгаа явуулах ажлыг зохион байгуулахыг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Нийцлийн аудитаар нийт 1,650.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1,650.0 мянган төгрөгийн акт тогтоож, зөрчил арилгуулах 2 албан шаардлага, 18 зөвлөмж хүргүүллээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Аймгийн ИТХ-ын тогтоолоор “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг баталсан боловч холбогдох хуульд нийцүүлэн боловсруулаагүйгээс хууль болон журмын заалтууд хоорондоо зөрчилдсөн, журам нь Хууль зүйн яамны “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдээгүй байна.
2. Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар баталсан тамхины тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой журмыг аймгийн Хууль зүйн хэлтсээр хянуулаагүй байна.
3. Согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгахдаа хуульд заасан хугацааг баримтлаагүй, шийдвэрлэх хугацааг хэтрүүлсэн байна.
4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгоход бүрдүүлэх баримт материалыг хуулийн дагуу бүрдүүлээгүй, байгууллагуудаас харилцан адилгүй баримт бичгийг хүлээн авсан байна.
5. Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоо нь нормативаас хэтэрсэн байна.
6. Согтууруулах ундаа, худалдах түүгээр үйлчлэх, тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг үнэн зөв ногдуулаагүй, бүрэн төвлөрүүлээгүй байна.
7. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй зарим ААНБ-ууд стандартын дагуу үйл ажиллагаа явуулахгүй байна.
8. Аймаг, сумдын ЗДТГ-аас согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудад хийгдсэн хяналт шалгалтын мөрөөр ажил зохион байгуулаагүй байна.
9. Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдын тусгай зөвшөөрөлтэй холбоотой ажлын тайлан, судалгаа ил тод мэдээлэгдээгүй байна.
10. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой өргөдөл, гомдлыг бүрэн бүртгээгүй, хуулийн хугацаанд шийдвэрлээгүй байна.
11. Шивээговь, Баянтал сумд нь архи, тамхины хуулийн талаар болон хор уршгийн талаар сургалт, сурталчилгаа явуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-д

1. “Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг хуульд нийцүүлэн боловсруулж, иргэдийн саналыг авсны үндсэн дээр дахин хэлэлцүүлж шинэчлэн батлах, Хууль зүйн яамны “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлэх

Аймгийн ХОХБТХ-ийн даргад:

1. Аймгийн ХЗХ-тэй хамтран сумдын гаргасан журам, түүний хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэвлүүлэх, бүртгэх, дугаарлах, түүнд хяналт тавих асуудлыг тодорхой болгон журамлах
2. Архи, согтууруулах ундааны тусгай зөвшөөрлийг сунгах болон шинээр олгох, хяналт тавих комиссын журмын дагуу жил бүрийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайлан болон холбогдох хурлын тэмдэглэл, бүрдүүлсэн баримт материалыг архивлах, ажлын тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар жилд нэг удаа хэлэлцүүлэх
3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгохдоо байгууллага тус бүрээр хувийн хэрэг бүрдүүлэх, баримт бичгийг бүрэн бүрдүүлсэн байгууллагад зөвшөөрлийг олгох
4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгахдаа хуульд заасан хугацааг баримтлах
5. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг үнэн зөв ногдуулж, бүрэн төвлөрүүлсний дараа байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, сунгалт хийх
6. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын үйл ажиллагааны стандартыг хангуулах, стандарт хангасан байгууллагад тусгай зөвшөөрөл олгох
7. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх талаар тогтоосон хууль журмын биелэлтэд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулах
8. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудад хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, зөрчилтэй болон удаа дараа зөрчил гаргасан иргэн, ААНБ-уудын тусгай зөвшөөрлийг цуцлах арга хэмжээ авах
9. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ил тод мэдээлэх
10. Архи, тамхины хууль болон хор уршгийн талаар сургалт, сурталчилгааг тогтмол явуулах

Сумдын Засаг даргад:

1. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг шинээр олгох болон сунгахдаа хуульд заасан хугацааг баримтлах, хуулийн хугацаанд шийдвэрлэх
2. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгохдоо байгууллага тус бүрээр хувийн хэрэг бүрдүүлэх, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэвлүүлэх, бүртгэх, дугаарлах, түүнд хяналт тавих асуудлыг тодорхой болгон журамлах
3. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн зайн зураглалыг баталгаажуулах, хуульд заасан нормативыг мөрдөж ажиллах
4. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгохдоо орон нутгийн эдийн засгийн өсөлт, бизнес эрхлэгчдийг дэмжих, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан нэгдсэн бодлого, чиглэлийг баримтлах
5. Тамхи худалдах тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг үнэн зөв ногдуулж, бүрэн төвлөрүүлсэн иргэн, ААНБ-уудад олгох
6. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх бүхий албан тушаалтны шийдвэр, ажлын тайлан, мэдээ судалгааг бэлтгэж, цахимаар ил тод мэдээлэх
7. Архи, тамхины хууль болон хор уршгийн талаар сургалт, сурталчилгааг тогтмол явуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн ХОХБХ-ээс ирүүлсэн санал:


**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**
42000 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Утас/Факс: (946) 7054 3005, И-мэйл: zdlg.gsa@gmail.com,
Вэбсайт: www.govisumber.gov.mn

2018.07.04 № 07/786
танай 2018.07.04-ны № 136 -т

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.САРАНТУЯА ТАНАА**

“Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт
согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр
үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, түүнд хяналт
тавих журмын хэрэгжилт”-д хийгдсэн Нийцлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Тус төсөлтэй холбоотой санал байхгүй
болно.


**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА** **Т.БАТ-ЭРДЭНЭ**

Б. Анхтуяа
Тайланг саймаар
орүүлж тайланг
сүхтэн гурвал
2018.07.04

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Аймгийн ХОХБХ-ээс ирүүлсэн албан бичигт тайлантай холбоотой санал, тайлбар байхгүй тул тайланд өөрчлөлт ороогүй болно.

Тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын судалгаа

Хавсралт №1

№	Байгууллагын нэр	Зөвшөөрлийн Төрөл		
		Согтууруулах ундаа худалдах	Согтууруулах ундаагаар үйлчлэх	Тамхи худалдах
1	Жеззабел ХХК	✓		
2	Гэээгт ЗБН /2-р баг /	✓		
3	Гэээгт ЗБН /3-р баг /	✓		✓
4	Сансарт хайрхан ХХК	✓		✓
5	ЭН-ДИ-ТИ ХХК	✓		✓
6	Тэргүүн сүмбэр ХХК	✓		✓
7	Залаагийн одь ХХК	✓		✓
8	Дэлгэрэх билэг ХХК Андууд мини маркет	✓		✓
9	ОЖС ХХК	✓		
10	Дэлгэрэх билэг ХХК Андууд 2	✓		
11	Дэлгэрэх билэг ХХК Андууд 1	✓		
12	Бидний Хад ХХК	✓		
13	УБТЗ Ган зам дэлгүүр	✓		
14	Уул баян сүмбэр ХХК	✓		✓
15	ДХББ ХХК	✓		
16	Шинэ Боржигон ХХК	✓		✓
17	Балдан засаг ХХК	✓		
18	Хүрээ инвест ХХК	✓		✓
19	Дорнын оточ ХХК	✓		✓
20	Мишээгч Очир ХХК Оргил Ундраа	✓		
21	Цамцат хайрхан ХХК	✓		
22	Анирце ХХК	✓		
23	Хөвхөрийн арал ХХК		✓	
24	Шинэ гранд ХХК		✓	
25	ББОГ ХХК		✓	
26	Бэлгэхэг хайрхан ХХК		✓	
27	Мэргэн дунгаа ХХК		✓	
28	ДСНБТ ХХК		✓	
29	Мишээгч Очир ХХК Наран кафе		✓	
30	Сүмбэр Алт ХХК		✓	
31	УБТЗ Чойр ресторан		✓	
32	Боржигон сондор ХХК		✓	
33	Идэрсайхан 41 дэлгүүр			✓
34	Дэвжих дэлгүүр			✓
35	Таван эрдэнэ дэлгүүр			✓
36	Жанжин дэлгүүр			✓
37	Залаат дэлгүүр			✓
38	Энх Оюу дэвжих ХХК	✓		
39	Шивээ сервис ХХК	✓	✓	✓
40	Шивээ сервис уулын цайны газар			✓
41	Чойр хайрхан сүмбэр ХХК	✓		
42	Хөгжил ЗБН	✓		
43	Насо ХХК	✓		
44	Шивээ мөнгөн ундарга ХХК		✓	
45	Бодь зам ХХК		✓	
46	Баянзолбоо дэлгүүр			✓
47	М.Цэндсүрэн Нэрт дэлгүүр			✓
48	Мөнхчимэг Уянга дэлгүүр			✓
49	Цэдэн хан ХХК	✓		
50	Оюут Боржигон ХХК	✓	✓	✓
51	Мөнххүлэг хурд ХХК	✓		✓
52	Арвижих 2 дэлгүүр			✓
53	Б.Хонгорзул дэлгүүр			✓
	Нийт	30	14	24

2017 оны А/137 засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн
 “Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй ААНБ-уудын үйл
 ажиллагаа”-нд хийсэн хяналт шалгалтын дүн

Хавсралт №2

№	Байгууллагын нэр	Авах оноо	Авсан оноо	Хувь
1	Шинэ Боржигон ХХК	96	75	78
2	Дэлгэрэхбилэг ХХК	96	81	84
3	Гэээгт ЗБН	96	77	80
4	Балдан засаг ХХК	96	82	85
5	Дэлгэрэхбилэг ХХК төв андууд	96	84	88
6	Залаагийн одь ХХК	96	88	92
7	ОЖС ХХК	96	67	70
8	Сансарт Хайрхан ХХК	96	59	61
9	Уул баян Сүмбэр ХХК	96	65	68
10	Хүрээ инвест ХХК	96	68	71
11	Насо ХХК	96	74	77
12	Энх оюу дэвжих ХХК	96	76	79
13	Чойр хайрхан сүмбэр ХХК	96	85	89
14	Шивээ сервис ХХК супермаркет	96	85	89
15	Мөнххүлэг хурд ХХК	96	59	61
16	Хөгжил ЗБН	96	54	56
17	Цэдэн хан ХХК	96	28	29
18	Тэргүүн Сүмбэр ХХК	96	72	75
19	Мишээгч Очир ХХК	96	79	82
20	Ган зам сүлжээ дэлгүүр	96	87	91
21	Цамцат хайрхан ХХК	96	64	67
22	Дорнын оточ ХХК	96	66	69
23	Бидний хад ХХК	96	72	75
24	Гэээгт ЗБН дугуй супермаркет	96	86	90
25	Жеззабел ХХК	96	66	69
26	Дэлгэрэхбилэг ХХК Андууд 2	96	69	72
27	Эн Ди Ти ХХК	96	65	68
28	ДСБНТ ХХК	126	118	94
29	Сүмбэр Алт ХХК	126	97	77
30	Оюут Боржигон ХХК	126	103	82
31	Шивээ мөнгөн ундарга ХХК	126	112	89
32	Бодь зам ХХК	126	91	72
33	Шивээ сервис ХХК БХТөв	126	122	97
34	Шинэ Гранд ХХК	126	72	57
35	Мишээгч Очир ХХК Наран кафе	126	98	78
36	ТЗ-ын ресторан	126	103	82
37	Боржигон Сондор ХХК	126	106	84
38	Мэргэн дунгаа ХХК	126	85	67
39	Хөвхөрийн арал ХХК	126	112	89